



**УСНЫ САН БҮХИЙ ГАЗАР, УСНЫ ЭХ ҮҮСВЭРИЙН
ОНЦГОЙ БОЛОН ЭНГИЙН ХАМГААЛАЛТЫН, ЭРҮҮЛ АХУЙН БҮСИЙН
ХИЛИЙГ ЗУРАГЛАХ АРГАЧЛАЛ**

Улаанбаатар хот

2025 он

Агуулга

Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн хилийг зураглах ерөнхий дараалал.....	3
НЭГ. УСНЫ САН БҮХИЙ ГАЗАР, УС ХАНГАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРИЙН ОРОН ЗАЙН СУУРЬ ДАТА БҮРДҮҮЛЭХ БОЛОН БЭЛТГЭХ	4
1.1 Усны сан бүхий газар, ус хангамжийн эх үүсвэрийн орон зайн суурь дата бүрдүүлэх.....	4
1.2 Усны сан бүхий газар болон ус хураах талбайг тодорхойлж, орон зайн суурь дата бэлтгэх.....	4
ХОЁР. Усны сан бүхий газар болон ус хангамжийн эх үүсвэрийг зураглах	5
ГУРАВ. Хамгаалалтын бүсийн хилийг зураглах	6
3.1 Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүсийн хилийг зураглах	6
3.2. Ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолт, хязгаарлалтын бүсийн хилийг зураглах	7
3.3. Хамгаалалтын бүсийн хилийн эргэлтийн цэгийн солбицлыг тодорхойлох....	7
ДӨРӨВ. Хянан баталгаажуулах, засварлах	8
4.1 Баталгаажуулалт хийх газрын мэдээллийг бэлтгэх	8
4.2 Хээрийн хэмжилт судалгаа хийх.....	8
4.3 Баталгаажуулалт хийх	8
ТАВ. Хамгаалалтын бүс тогтоох захиргааны хэм хэмжээний актын төслийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн бэлтгэх	8
5.1 Хэлэлцүүлэг зохион байгуулах	9
5.2 Дүгнэлт гаргуулах.....	9
5.3 Хамгаалалтын бүс тогтоох тогтоолын төслийн хавсралт бэлдэх.....	9
Хавсралт	9


Ерөнхий зүйл

1. Энэхүү аргачилсан зааврыг усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн хилийг зураглахад мөрдлөг болгоно.
2. Аргачилсан заавар нь усны сан бүхий газар, ус хангамжийн эх үүсвэрийн суурь дата мэдээлэл бүрдүүлэх, усны сан бүхий газар болон ус хангамжийн эх үүсвэр, тэдгээрийн хамгаалалтын бүсийн хилийг зураглах аргачлал болон хамгаалалтын бүсийн хилийн цэсийг бэлдэх жишиг маягтаас бүрдэнэ.

Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн хилийг зураглах ерөнхий дараалал

Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолт, хязгаарлалтын бүсийг зураглах ажлыг Усны тухай хууль, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Барилга хот байгуулалтын сайдын 2015 оны А-230/127 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан журам болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн доор дурдсан аргачлал, дарааллын дагуу гүйцэтгэнэ.

Хамгаалалтын бүс зураглах ажлын ерөнхий дараалал.



НЭГ. УСНЫ САН БҮХИЙ ГАЗАР, УС ХАНГАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРИЙН ОРОН ЗАЙН СУУРЬ ДАТА БҮРДҮҮЛЭХ БОЛОН БЭЛТГЭХ

1.1 Усны сан бүхий газар, ус хангамжийн эх үүсвэрийн орон зайн суурь дата бүрдүүлэх

Суурь дата бүрдүүлэхдээ тухайн мэдээллийг бүрдүүлэх, хадгалах, тархаах эрх бүхий байгууллагуудаас дараах дата, мэдээллийг бүрдүүлнэ. Үүнд:

1.1.1. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар:

- а. Улсын болон засаг захиргааны нэгжийн хилийн орон зайн дата;
- б. Байрзүйн 1:100000 масштабтай зургийн (JPG) файл;
- в. Сумдын газар нутгийн нэрийн зургийн (JPG) файл;
- г. Газрын нэгдмэл сангийн усны сан бүхий газрын орон зайн дата;
- д. Газрын кадастрын нэгж талбарын орон зайн дата;

1.1.2. Усны газар, Сав газрын захиргаад:

- а. Усны тоо бүртгэлийн орон зайн дата;
- б. Гол мөрний урсац бүрэлдэх эх, сав газрын хилийн орон зайн дата;

1.1.3. Аймгийн Байгаль орчны газар:

- а. Аймгийн хэмжээнд болон хэсэгчилсэн байдлаар хамгаалалтын бүс тогтоож байсан тогтоол шийдвэр, хамгаалалтын бүсийн оронзайн дата;

1.1.4. Аймгийн Барилга, хот байгуулалтын газар:

- а. Аймаг, сумдын усны барилга байгууламжийн орон зайн дата (үерийн хамгаалалтын далан, суваг, урсацын тохируулгатай усан сан);
- б. Ус хангамжийн эх үүсвэрийн орон зайн дата;

1.1.5. Ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээ эрхэлсэн байгууллага:

- а. Хүн амын ус хангамжийн төвлөрсөн болон төвлөрсөн бус эх үүсвэрийн орон зайн дата;

1.1.6. Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар болон Дэ Нэйче Консерванси (TNC) байгууллага.

- а. Гол, нуурын эрэг орчмын ус намгархаг газар, татам зурагласан үр дүн. 2014 он.

Төрийн болон албаны нууцад хамаарах мэдээлэлтэй танилцах, хадгалах, дамжуулахдаа холбогдох хууль, журам, зааврыг дагаж мөрдөнө.

1.2 Усны сан бүхий газар болон ус хураах талбайг тодорхойлж, орон зайн суурь дата бэлтгэх


Өндөр нарийвчлалтай (10 метрээс бага) хиймэл дагуулын дата ашиглан усаар бүрхэгдсэн талбайн орон зайн датаг бүрдүүлэх, өндрийн тоон загвар (DEM) ашиглан урсацын сүлжээ болон ус хараах талбайг тодорхойлно.

1.2.1 Сансрын зургаас усаар бүрхэгдсэн талбайн орон зайн датаг бүрдүүлэх

- а. Газрын бүрхэвчийн ангиллын зурагнаас усаар бүрхэгдсэн талбайн орон зайн датаг ялгаж бэлтгэнэ.
- 1.2.2 Өндрийн тоон загвар ашиглан урсацын сүлжээ болон ус хураах талбайн хилийг тодорхойлох
- а. Урсацын сүлжээ буюу голын сүлжээ байгуулсан орон зайн дата бэлтгэнэ;
 - б. Ус хураах талбайн хилийн орон зайн дата бэлтгэнэ.

ХОЁР. Усны сан бүхий газар болон ус хангамжийн эх үүсвэрийг зураглах

Усны сан бүхий газрыг зураглах ерөнхий дараалал.



Хиймэл дагуулын зургаас ялгарч харагдахгүй говь, хээрийн бүсийн түр зуурын урсацтай голууд болон жижиг гол, горхийг зураглахдаа үерийн урсацын загварын үр дүн (30 буюу түүнээс олон жилд нэг удаа тохиох үерийн хамгийн их урсацын хилээр)-г ашиглаж болно.

2.1 Усны сан бүхий газрыг зураглах

- 2.1.1 Усны сан бүхий газрыг зураглахдаа 1.1-д бүрдүүлсэн орон зайн суурь датаг 1.2-д заасан орон зайн дата боловсруулан гаргасан үр дүнтэй давхцуулан харьцуулах замаар зураглана.
- 2.1.2 Усны сан бүхий газрыг зурагласан үр дүн буюу 2.1.1-ээс гарсан үр дүнг өндөр нарийвчлалтай онлайн хиймэл дагуул (ESRI, Google map)-ын зургаар тодруулан орхигдсон жижиг гол горхи, нуур тойром, булаг шандыг гараар дагуулан зураглаж (дигитайз хийх) усны сан бүхий газрыг зураглана.

2.2 Ус хангамжийн эх үүсвэрийг зураглах

- 2.2.1 Ус хангамжийн эх үүсвэрийн орон зайн дата буюу 1.1.1.д, 1.1.2.а хэсэгт бүрдүүлсэн датаг давхцуулан харьцуулах замаар ус хангамжийн эх үүсвэрийн орон зайн датаг бэлтгэнэ.

2.2.2 Ус хангамжийн эх үүсвэрийн орон зайн дата буюу 1.1.1.д, 1.1.2.а хэсэгт бүртгэгдээгүй ус хангамжийн эх үүсвэрийг өндөр нарийвчлалтай онлайн хиймэл дагуул (ESRI, Google map)-ын зургаар тодруулан зураглана.


2.3 Усны сан бүхий газар болон ус хангамжийн эх үүсвэрийг тодорхойлох мэдээлэл (аттрибут мэдээлэл)-ийг үүсгэх

2.3.1 Усны сан бүхий газар болон ус хангамжийн эх үүсвэрийг зураглахдаа сав газрын нэр, аймаг, сумын нэр, газрын нэр, гол, нуур, булаг, ус хангамжийн эх үүсвэрийн нэр гэсэн аттрибут мэдээлэлийг давхар үүсгэх ба тус мэдээлэл нь хамгаалалтын бүсийн хилийн цэсийн солбицлын хамт батлагдана.

ГУРАВ. Хамгаалалтын бүсийн хилийг зураглах

Хамгаалалтын бүсийн хилийг зураглахдаа 2 дугаар бүлгээс гарсан үр дүн буюу усны сан бүхий газар, ус хангамжийн эх үүсвэрийг зурагласан үр дүнд тулгуурлан, Усны тухай хууль, БОНХАЖ-ын сайд, БХБ-ын сайдын 2015 оны 230/127 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан дэглэмд заасны дагуу дараах байдлаар зураглана.

Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн хамгаалалтын бүсийн хилийг зураглах ерөнхий дараалал



3.1 Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүсийн хилийг зураглах

3.1.1. Онцгой хамгаалалтын бүсийн хилийг зураглах

- Гол горхи, булаг шандын эргээс 50 метрээр зурвас (buffer) татаж зураглана.
- Нуур, усан сангийн эргээс 100 метрээр зурвас (buffer) татаж зураглана.

- в. Хот, аймгийн төвийн нутаг дэвсгэр дэх усны сан бүхий газрын эргээс 200 метрээр зурвас (buffer) татаж зураглана.
- г. 50 метрээс өргөн, намаг бүхий татамтай гол, горхи, булаг, шандын онцгой хамгаалалтын бүсийн хилийг зураглахдаа Монгол орны гол, нуурын эрэг орчмын татмын байгалийн хилийг зурагласан үр дүн (1.1.6-ын а.-д заасан дата)-тэй харьцуулан татмын хилээр зураглана.

3.1.2. Энгийн хамгаалалтын бүсийг зураглах

- а. Гол горхи, булаг шандын эргээс 200 метр буюу онцгой хамгаалалтын бүсийн хил (50 метр)-ээс 150 метрээр зурвас (buffer) татаж зураглана.
- б. Нуур, усан сангийн эргээс 200 метр буюу нуур усан сангийн онцгой хамгаалалтын бүсийн хил (100 метр)-ээс 100 метрээр зурвас (buffer) татаж зураглана.
- в. Хот, аймгийн төвийн нутаг дэвсгэр дэх энгийн хамгаалалтын бүсийг зураглахдаа усны сан бүхий газрын эргээс 1000 метр хүртэл буюу онцгой хамгаалалтын бүсийн хил (50 метр)-ээс 950 метр хүртэлх өргөнтэй зурвас (buffer) татаж зураглана.

3.2. Ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолт, хязгаарлалтын бүсийн хилийг зураглах.

3.2.1. Эрүүл ахуйн хориглолтын бүсийн хилийг зураглах

- а. Төвлөрсөн буюу инженерийн шугам сүлжээнд холбогдсон ус хангамжийн эх үүсвэрийн худгаас 100 метрээр зурвас (buffer) татаж зураглана.
- б. Төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрийн худгаас 50 метрээр зурвас (buffer) татаж зураглана.

3.2.2. Эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийг зураглах

- а. Ус хангамжийн эх үүсвэрийн худгаас 200 метр буюу төвлөрсөн сүлжээнд холбогдсон ус хангамжийн эх үүсвэрийн худгийн эрүүл ахуйн хориглолтын бүсийн хил (100 метр)-ээс 100 метр, төвлөрсөн бус эх үүсвэрийн худгийн эрүүл ахуйн хориглолтын бүсийн хил (50 метр)-ээс 150 метр зурвас (buffer) татаж зураглана.

3.3. Хамгаалалтын бүсийн хилийн эргэлтийн цэгийн солбицлыг тодорхойлох

3.3.1. Хамгаалалтын бүсийн хилийг засварлах

- а. Цутгал голуудын хамгаалалтын бүсийн хилийн давхцалыг арилгаж үндсэн голын хамгаалалтын бүсээр авна.

3.3.2. Хамгаалалтын бүсийн хилийн эргэлтийн цэгийн солбицлыг тодорхойлох

- а. Солбицлыг газарзүйн координатын систем буюу градус, минут, секунд болон градусын бутархай (decimal degrees)-гаар тодорхойлно.
- б. Солбицлыг тодорхойлохдоо тухайн бүс нутагт харгалзах тэгш өнцөгтийн координатын системийн бүсчлэл (zone)-ийг тохируулсан байх шаардлагатай.

3.3.3. Хамгаалалтын бүсийн талбайг тооцоолох

- а. Онцгой хамгаалалтын бүс болон эрүүл ахуйн хориглолтын бүсийн талбайг тооцохдоо усны сан бүхий газар болон усны эх үүсвэрийн талбайг хасаж тооцохгүй.

б. Энгийн хамгаалалтын бүс болон эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийн талбайг тооцохдоо онцгой хамгаалалтын болон эрүүл ахуйн хориглолтын бүсийн талбайг хасаж тооцохгүй.

ДӨРӨВ. Хянан баталгаажуулах, засварлах

4.1 Баталгаажуулалт хийх газрын мэдээллийг бэлтгэх

- 4.1.1. Усны сан бүхий газрыг зураглах явцад газар дээр нь очиж тодруулах шаардлагатай нуур тойром, гол горхи, булаг шандын жагсаалтыг гаргах, ажлын зураг бэлдэнэ.
- 4.1.2. Хамгаалалтын бүсийг зураглах явцад голын татам буюу байгалийн хил тодорхой ялгарч байгаа болон ялгарахгүй байгаа эргэлзээ төрүүлсэн талбайг төлөөлүүлэн сонгож, тэдгээрээс санамсаргүй байдлаар эргэлтийн цэг сонгоно.
- 4.1.3. Сонгосон цэгийн байршил тогтоогч GPS-д оруулна.

4.2 Хээрийн хэмжилт судалгаа хийх


- 4.2.1. Сонгож авсан талбай болон, хамгаалалтын бүсийн эргэлтийн цэгийг шалгах, тухайн талбайд ажиллаж байгалийн хилийн эргэлтийн цэгүүдийг авах. Зөрүү үүссэн байршлыг тэмдэглэнэ.
- 4.2.2 Тухайн орон нутагт ажиллах явцдаа тодруулах шаардлагатай усны сан бүхий газар болон, ус хангамжийн эх үүсвэрийг нутгийн иргэдээс тодруулах, газар дээр нь очиж баталгаажуулж солбицлыг авна.
- 4.2.3 Орон нутагт ажиллах үеэр ус хангамжийн эх үүсвэрийн худгууд, үерийн хамгаалалтын барилга байгууламж, бохирдуулагч эх үүсвэр болох цэвэрлэх байгууламж, хогийн цэгийн бүртгэлийг авна.

4.3 Баталгаажуулалт хийх

- 4.3.1 Хээрийн хэмжилт судалгаа, газар дээр нь тодруулсан мэдээллүүдийг тулгаж, алдааг засварлана.
- 4.3.2 Хээрийн хэмжилт судалгаагаар зөрүү үүсээгүй бол хамгаалалтын бүсийн зураглалд алдаа үүсээгүй гэж үзэн үр дүнг хэлэлцүүлэх, дүгнэлт гаргуулах үе шатны ажилд бэлтгэнэ.

ТАВ. Хамгаалалтын бүс тогтоох захиргааны хэм хэмжээний актын төслийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн бэлтгэх

Санал, дүгнэлт гаргуулах ажлын зохион байгуулалтын бүдүүвч.



5.1 Хэлэлцүүлэг зохион байгуулах

- 5.1.1. Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлийн 62.1-д заасны дагуу хамгаалалтын бүс тогтоох захиргааны хэм хэмжээний актыг төслийг тухайн захиргааны байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт 30-аас доошгүй хоногийн хугацаанд байрлуулж санал авна.
- 5.1.2. Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлийн 62.2-т заасны дагуу ...эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх бүлгийн хүрээнд хэлэлцүүлэг хийнэ.
- 5.1.3. 5.1.1, 5.1.2-оос гарсан санал, зөвлөмжийг аргачлалын 2, 3 дахь бүлэгт заасан хэсэгт тусгаж засварлана.
- 5.1.4. Захиргааны ерөнхий хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.1-д заасны дагуу хэлэлцүүлгийн тэмдэглэл, гарсан саналыг тусгасан талаарх тайлан, мэдээллийг бүрдүүлнэ.

5.2 Дүгнэлт гаргуулах

- 5.2.1. Хамгаалалтын бүс тогтоох асуудлаар Усны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4-т заасны дагуу хот суурины ус хангамж, ариутгах татуургын асуудал эрхэлсэн болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлт гаргуулах.
- 5.2.2 5.2.1-ээс гарсан гарсан санал, зөвлөмжийг аргачлалын 2, 3 дахь бүлэгт заасан хэсэгт тусгаж засварлана.

5.3 Хамгаалалтын бүс тогтоох тогтоолын төслийн хавсралт бэлдэх

- 5.3.1. Хот суурины ус хангамж, ариутгах татуургын асуудал эрхэлсэн болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлт;
- 5.3.2. Хэлэлцүүлгийн тэмдэглэл, гарсан саналыг тусгасан талаарх тайлан;
- 5.3.3. Хамгаалалтын бүсийн хилийн цэсийн солбицлыг хавсралт 1-4-т заасны дагуу бэлтгэнэ.

Хавсралт

Хүснэгт 1. Аймгийн ИТХ-ын тогтоолын хавсралт

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ... оны ... дугаар сарын ...-ны өдрийн ээлжит ... хуралдааны ... тогтоолын ... дугаар хавсралт

Сав газар	№	Сумын нэр	Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс	
			Онцгой хамгаалалтын бүсийн талбай, га	Энгийн хамгаалалтын бүсийн талбай, га
Дэлгэрмөрөн	1	Мөрөн		
	2	Алаг-эрдэнэ		
	3	Арбулаг		
	4	Баянзүрх		
	5	Бүрэнтогтох		
	6			
Хөвсгөл нуур-Эг	1	Алаг-эрдэнэ		
	2	Арбулаг		
	3	Их-уул		
	4	Ренчинлхүмбэ		
	5			
Шишхэд	1	Алаг-эрдэнэ		
	2	Баянзүрх		
	3	Ренчинлхүмбэ		
	4			

№	Сумын нэр	Ус хангамжийн эх үүсвэрийн тоо	Усны эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс, га	
			Хориглолтын бүс	Хязгаарлалтын бүс
1	Мөрөн			
2	Алаг-эрдэнэ			
3	Арбулаг			
4	Баянзүрх			
5	Бүрэнтогтох			
6	Галт			
7	Жаргалант			
8	Их-уул			
9	Рашаант			
10				

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ... оны ... дугаар сарын ...-ны өдрийн ээлжит ... хуралдааны ... тогтоолын ... дугаар хавсралт

УСНЫ САН БҮХИЙ ГАЗРЫН ОНЦГОЙ ХАМГААЛАЛТЫН БҮСИЙН ХИЛИЙН ЗААГИЙН СОЛБИЦОЛ

№	Голын нэр	Цэгийн дугаар	Уртраг	Өргөрөг	X	Y
Дэлгэмөрөн голын сав газар						
1	Дэлгэмөрөн	1				
		2				

№	Нуурын нэр	Цэгийн дугаар	Уртраг	Өргөрөг	X	Y
Хөвсгөл нуур-Эгийн голын сав газар						
1	Хөвсгөл	1				
		2				

№	Булгийн нэр	Цэгийн дугаар	Уртраг	Өргөрөг	X	Y
Идэр голын сав газар						
1	Битүүгийн булаг	1				
		2				

Тусгаг, солбицлын тогтолцоо: WGS 1984 UTM Zone 46 -50N

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын ... оны ... дугаар сарын ...-ны
өдрийн ээлжит ... хуралдааны ...
тогтоолын ... дугаар хавсралт

УСНЫ САН БҮХИЙ ГАЗРЫН ЭНГИЙН ХАМГААЛАЛТЫН БҮСИЙН ХИЛИЙН ЗААГИЙН СОЛБИЦОЛ

№	Голын нэр	Цэгийн дугаар	Уртраг	Өргөрөг	X	Y
Дэлгэмөрөн голын сав газар						
1	Дэлгэмөрөн	1				
		2				

№	Нуурын нэр	Цэгийн дугаар	Уртраг	Өргөрөг	X	Y
Хөвсгөл нуур-Эгийн голын сав газар						
1	Хөвсгөл	1				
		2				

№	Булгийн нэр	Цэгийн дугаар	Уртраг	Өргөрөг	X	Y
Идэр голын сав газар						
1	Битүүгийн булаг	1				
		2				
		3				

Тусгаг, солбицлын тогтолцоо: WGS 1984 UTM Zone 46 -50N

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын ... оны ... дугаар сарын ...-
ны өдрийн ээлжит ... хуралдааны
... тогтоолын ... дугаар хавсралт

УС ХАНГАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРИЙН ЭРҮҮЛ АХУЙН ХОРИГЛОЛТЫН БҮСИЙН
ХИЛИЙН ЗААГИЙН СОЛБИЦОЛ

№	Сумын нэр	Эх үүсвэрийн нэр	Цэгийн дугаар	Уртраг	Өргөрөг	X	Y
1	Сумын нэр 1	Худаг 1	1				
2			2				
3			3				
1	Сумын нэр 1	Худаг 2	1				
2			2				
3			3				

Тусгаг, солбицлын тогтолцоо: WGS 1984 UTM Zone 46 -50N

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ...
оны ... дугаар сарын ...-ны өдрийн ээлжит ...
хуралдааны ... тогтоолын ... дугаар хавсралт

УС ХАНГАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРИЙН ЭРҮҮЛ АХУЙН ХЯЗГААРЛАЛТЫН
БҮСИЙН ХИЛИЙН ЗААГИЙН СОЛБИЦОЛ

№	Сумын нэр	Эх үүсвэрийн нэр	Цэгийн дугаар	Уртраг	Өргөрөг	X	Y
1	Сумын нэр 1	Худаг 1	1				
2			2				
3			3				
1	Сумын нэр 1	Худаг 2	1				
2			2				
3			3				

Тусгаг, солбицлын тогтолцоо: WGS 1984 UTM Zone 46 -50N